

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.

2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Монгол нутаг дээр анх хэдий үед хүн амьдарч байсан хэмээн өнөөгийн түүхийн шинжлэх ухаан үзэж байна вэ? /1 оноо/

A. 200 000 жилийн тэртээ	B. 500 000 жилийн тэртээ	C. 800 000 жилийн тэртээ
D. 1 сая жилийн тэртээ	E. 1.2 жилийн тэртээ	
2. Дунд чулуун зэвсгийг хэдий үед хэрэглэж байсан бэ? /1 оноо/

A. 800 000-100 000 жилийн үед	B. 100 000-40 000 жилийн үед	E. 8000-3000 жилийн үед
C. 40 000-15 000 жилийн үед	D. 15 000-8000 жилийн үед	
3. Аль нь аргын тоолол хэмээх ойлголтыг илэрхийлж байна вэ? /1 оноо/

A. Сарны хөдөлгөөнд тулгуурласан	B. Нарны хөдөлгөөнд тулгуурласан
C. Манай гарагийн хөдөлгөөнд тулгуурласан	E. А ба В хариулт хамаарна
D. А ба С хариулт хамаарна	
4. Дор дурьдсан он тооллоос Монголчуудын уламжлалт билгийн он тоололд хамаарахыг нь нэрлэнэ үү? /1 оноо/

A. Олноо өргөгдсний 3 дугаар он	B. Монгол улсын 14 дүгээр он	E. XVII жарны усан могой жил
C. Хэвт ёсны 2 дугаар он	D. 2013 он	
5. Дор өгүүлсэн зүйлээс хүрэл болон төмөр зэвсэгтний эхэн үеийн аймгийн холбоо гэсэн ойлголтыг илэрхийлж байгаа гол шинжийг нь нэрлэнэ үү? /1 оноо/

A. Төрөл бус хэд хэдэн аймгууд цэргийн хүчирхэг удирдагчийн захиргаанд нэгдсэн
B. Төр үүсэхийн өмнөх зохион байгуулалтын хэлбэр
C. Ураг төрлийн холбоо бүхий овгуудын нэгдэл.
D. А ба В хариулт хамаарна.
E. В ба С хариулт хамаарна.
6. Монгол нутагт өргөн тархсан хадны сүг зургийг үйлдсэн аргаар нь юу гэж ангилдаг вэ? /1 оноо/

A. Зураасан ба цохимол	B. Зураасан ба сийлмэл	C. Сийлмэл ба цохимол
D. Зурмал ба зураасан	E. Зосон ба сийлмэл	
7. Эртний хүмүүсийн амьдралд байгалийн нөхцөл ямар нөлөө үзүүлж байсан бэ? /1 оноо/

A. Эртний хүмүүсийн амьдралд анхдагч ач холбогдолтой
B. Байгалийн нөхцөл нь хүн, нийгмийн хөгжилд ихээхэн нөлөө үзүүлдэг байлаа
C. Байгаль, цаг уурын нөхцөл хүмүүсийн гадаад төрх, бие бялдар, сэтгэлгээ зэрэгт нөлөөлдөг.
D. Дээрх бүх хариулт хамаарна.
E. А ба В хариулт хамаарна.
8. Хүннү гүрэн Хан улсын хооронд НТӨ 198 онд гэрээ байгуулжээ. Энэ нь хэддүгээр зууны хэддүгээр хагаст болсон бэ? /1 оноо/

A. НТӨ I зууны II хагас	B. НТӨ I зууны I хагас	C. НТӨ II зууны I хагас
D. НТӨ II зууны II хагас	E. НТӨ III зууны I хагас	
9. Сяньбигийн төрийн эрх баригч бөгөөд Ухуань нарыг нэгтгэж, Солонгосын хойг хүртэл нутгаа тэлсэн, ухаалаг, алсын хараатай, төрийн төвшин нуруутай удирдагч нь хэн байсан бэ? /1 оноо/

A. Модунь	B. Таньшихуай	C. Кэбинэн	D. Мугулюй	E. Чаругуй
-----------	---------------	------------	------------	------------
10. Хүннү гүрэн задарсан шалтгааныг дурьдахдаа буруу ташаа зүйл өгүүлсэн байна уу? /1 оноо/

A. Түрэг аймгуудын довтолгоон
B. Хятадын Хан улсын дотроос нь хагалан бутаргах гэсэн үйл явуулга
C. Дотооддоо эв нэгдэлтэй байж чадаагүй, язгууртнуудын өөр хоорондын тэмцэл
D. Эрхшээлд нь байсан аймгуудын тусгаарлах гэсэн эрмэлзлэл
E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.
11. Монголын эртний улсуудын Монголын болон дэлхий дахины түүхэнд оруулсан гол хувь нэмэр юу вэ? /2 оноо/

A. Засаг захиргааны аравтын зохион байгуулалтыг хэрэглэсэн
B. Хаанаа “тэнгэрийн хүү” хэмээн шүтэх, төрөө дээдлэх үзлийг бий болгосон
C. Бэлчээрийн сонгодог аж ахуйг бий болгож хөгжүүлсэн.
D. Нүүдэлчдийн өвөрмөц иргэншлийг бий болгосон
E. Дээрх бүгд хамаарна.

12. XI-XII зууны үед Хэрэйд аймгийн нутаг нь хаагуур байсан бэ? /1 оноо/
 А. Заг Байдраг, Сэлэнгэ Туул, Элсэн говийн хооронд В. Орхоны адаг, Сэлэнгийн дунд биеэр
 С. Хөлөн Буйр нуураар төвлөрч байв. D. Хэрлэн, Онон, Туул голын сав газраа
 Е. Орхон голоос Эрчис мөрөн, Хангайн нуруунаас Алтайн чанад хүрч байв.
13. Эргүнэ-гүнгийн Монголчуудын ерөнхий нэр юу вэ? /1 оноо/
 А. Нирун В. Боржигон С. Дарлиган D. Салжиуд Е. Хатиган
14. XIII зууны эхэн үед Монголын баруун өмнөд талд ямар улс оршин байв? /1 оноо/
 А. Сүн улс В. Алтан улс С. Си-Ся буюу Тангуд улс D. Хорезми Е. Хятан
15. Дараах өгөгдлүүдэд буруу зүйл өгүүлсэн байна уу? /2 оноо/
 А. Чингисийн чулуу хэмээн алдаршсан гэрэлт хөшөөг 1225 оны орчим босгожээ.
 В. Хархорумыг Чингис хааны зарлигаар 1229 онд барьж эхэлжээ.
 С. Манай нэрт эрдэмтэн Цэндийн Дамдинсүрэн “Монголын нууц товчоо”-г 1240 онд зохиосон хэмээн үзжээ.
 D. 1269 онд Пагба ламын зохиосон Дөрвөлжин үсэг бичгийг төрийн албан ёсны бичиг болгожээ.
 Е. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.
16. Их Монгол улсын Их заргач буюу төрийн заргачаар Чингис хаан анх хэнийг томилсон бэ? /1 оноо/
 А. Мухулай В. Шихихутаг С. Боорчи D. Зэлмэ Е. Наяа
17. 1206 онд байгуулагдсан Их Монгол улсын хилийн хойд тал нь хаагуур хиллэж байсан бэ? /1 оноо/
 А. Байгаль нуур В. Түмэн газрын цагаан хэрэм
 С. Хянганы нуруу D. Алтайн нурууны чанад Е. Хөвсгөлийн уулс
18. Чингис хааны зарлиг ёсоор Өгөдэйг хаан өргөмжилсөн Хэрлэний хөдөө арал монголын өнөөгийн засаг захиргааны хуваариар ямар аймгийн нутагт байдаг вэ? /1 оноо/
 А. Сүхбаатар аймаг В. Төв аймаг С. Дорнод аймаг
 D. Хэнтий аймаг Е. Өвөрхангай аймаг
19. Дор дурьдсан үйл явдлуудыг болсон цаг хугацааны дагуу эрэмбэлнэ үү? /2 оноо/
 1. Хубилай улсаа Юань хэмээн нэрлэв.
 2. Гүюг хаан хүн малын тооллого явуулжээ.
 3. Онон мөрний эхэнд Монголын ноёдын Их хуралдай хуралдаж, Их Монгол улсыг байгуулагдсаныг тунхаглан зарлав.
 4. Алтан орд улс задран, Монголын ноёрхол унав.
 А. 1, 3, 4, 2 В. 1, 2, 4, 3 С. 4, 3, 2, 1 D. 3, 2, 1, 4 Е. 2, 4, 1, 3
20. Чингис хааны гадагш хийсэн аян дайндаа амжилт олоход нөлөөлсөн зарим хүчин зүйлийг дурьдахдаа илүүц зүйл өгүүлсэн байна уу? /2 оноо/
 А. Тулалдах этгээдээ сайтар тагнан мэдэж, улс хот бүрд тохирсон арга тактик хэрэглэдэг байсан.
 В. Чингис хааны цэрэг төмөр мэт сахилга баттай байсан.
 С. Цэргийг удирдах цэргийн жанжныг бэлтгэхдээ гарал угсааг бус цэргийн хэргийн эрдмийг гол зарчим болгож байсан.
 D. Монгол хүн, монгол морь хоёрын холын аянг даах чадварыг ашигласан.
 Е. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.
21. 1241 онд Өгөдэй хаан тэнгэрт хальсны дараа алтан ургийнхны хаан ширээний төлөөх тэмцэл хурцаджээ. Үүний үндэс болсон зүйл нь юу байсныг олж тэмдэглэнэ үү? /2 оноо/
 А. Чингисийн хоёр дахь хөвгүүн Зүчи хаан суухыг хүсэмжилж байсан
 В. Өгөдэй хааны нэр гэрээслэсэн Хүчү дайнд нас барж, Ширэмүн нас бага байсан.
 С. Чингисийн отгон хүү Тулуй хаан суух ээлж ирсэн хэмээн ойлгож, тэмцэж байсан
 D. Энэ тэмцэлд нэг талаас Зүчи, Өгөдэйн угсааныхан, нөгөө төлөөс Цагадай, Тулуйн угсааныхан нэгдэж тэмцэж эхлэв.
 Е. Өгөдэйн хөвгүүн Гүюг хаан ширээнд суухаас татгалзсан.
22. Чингис хааныг 2 дахь мянганы алдарт хүнээр тодруулсан “Вашингтон пост” сонины гол үндэслэлийг дурьдахдаа ташаа зүйл өгүүлсэн байна уу? /2 оноо/
 А. Дэлхий хэмжээний эзэнт гүрнийг байгуулсан.
 В. Өрнө дорнын соёл иргэншлийн хэлхээ холбооны эхийг тавьсан.
 С. Америк тивийг нээж Европ-Америкийг холбосон.
 D. А ба В хариулт зөв. Е. В ба С хариулт зөв.


23. Дараах бичвэрт цэгийн оронд тохирох үгийг нөхөн бичнэ үү? /2 оноо/
 XIII-XIV зууны үеийн хаад, ноёд, том хэмжээний, гоёж чимэглэсэн 1. зэрэг орд гэр хэрэглэж, эрэгтэйчүүд нь 2. хэлбэрийн малгай, харин гэрлэсэн эмэгтэйчүүд нь 3. малгай өмсөнө. 4..... нь тал хээрийн дайчин эрсийн гавьяаг илтгэх, эр хүн гэдгийг тодотгох гол хэрэглэлийн нэг болж байв.
- a.Амьтны арьс үсээр хийсэн хувцас b.Алтан тэрэм c. Бүс
 d. Богтаг e. Юүдэн f. Босоо захгүй дээл
- A. 1a, 2b, 3e, 4c B. 1f, 2d, 3e, 4a C. 1a, 2d, 3c, 4b
 D. 1b, 2e, 3d, 4c E. 1b, 2e, 3e, 4f
24. Монголын түүхэнд” бага хаадын үе” гэж аль үеийг нэрлэдэг вэ? /1 оноо/
 A. 1206-1260 он B. 1260-1368 он C. 1368-1634 он
 D.1634-1691 он E. 1691-1911 он
25. Улс төрийн бутралын үеийн зүүн Монголын бүрэлдэхүүнд багтаж байсан зүүн гарын түмнүүдийг нэрлэхдээ буруу зүйл оруулсан байна уу? /1 оноо/
 A. Халх B. Урианхай C. Цахар
 D.12 түмэд E. Тийм зүйл өгүүлээгүй байна.
26. Мандухай цэцэн хатан Батмөнх даян хааны нэрийн өмнөөс төрийн эрхийг нэгэн хэсэг хугацаанд барьж байсан. Үүний гол учир нь юу вэ? /2 оноо/
 A. Мандухай эрх мэдэл албан тушаалд шунасан.
 B. Мандухай хатан төрийн эрхийг барих заль мэх хэрэглэсэн.
 C. Батмөнх даян хаан насан бага балчир байсан.
 D. А ба В хариулт зөв E. В ба С хариулт зөв.
27. Монголын Алтан ургийн сүүлчийн хаан хэн бэ? /1 оноо/
 A. Автай сайн хан B. Түмэн засагт хан C. Алтан хан
 D. Батмөнх даян хаан E. Лигдэн хаан
28. “Байшин” хэмээх хот байгуулсан нь хожмын Өвөр Монголын төв Хөх хот болжээ. Хэн энэ хотын үндэс суурийг тавьсан бэ? /1 оноо/
 A. Автай сайн хан B. Түмэн засагт хан C. Алтан хан
 D. Батмөнх даян хаан E. Лигдэн хаан
29. 1630-аад оны төгсгөлөөр Халхын ноёдын нэгэн бичигт “...хаан хүмүүнд хас их төр, хамагт сонсогдох сайн алдар нэр хамгаас хэрэгтэй тул хамгаас төр шашныг мандуулах нэрийг эрэлдье. Зургаан түмний эзэн биднийг жолоодон эс чадав. Тэр эс чадавч бидний өөргүйн тулд хас их төрийг хадгалж суунам бид” хэмээн өгүүлжээ. Энэ баримт ямар утга санааг илэрхийлж байна вэ? /2 оноо/
 A. Хаан биднийг жолоодон захирч чадсангүй.
 B. Харин Халхын ноёд төрөө алдалгүй хадгалж байсныг
 C. Хаан хүний эрхэмлэх зүйлийн тухай
 D. Дээрх бүгдийн тухай өгүүлжээ.
 E. Зөвхөн В ба С-д хамаарах асуудлын тухай өгүүлжээ.
30. Манжийг эсэргүүцсэн Лигдэн хааны тэмцлийг Халхын ноёдоос хэн нь тууштай дэмжиж байсан бэ? /1 оноо/
 A. Гүүш хан Төрбайх B. Цогт хунтайж C. Сэцэн хан Норов
 D.Түшээт хан Чахундорж E. Галдан бошогт
31. 1691 онд Долнуурт болсон чуулганаар Халх Монголыг Манж Чин улсын харьяанд орсныг албан ёсоор тунхаглан зарлажээ.Энэ билгийн тооллоор хэддүгээр жаранд болсон бэ? /1 оноо/
 A. 9 дүгээр жаран B. 10 дугаар жаран C. 11 дүгээр жаран
 D.12 дугаар жаран E. 13 дугаар жаран
32. Манж Чин гүрний эрхшээлд орсон нь монголчуудад ямар нөлөө үзүүлсэн бэ? /2 оноо/
 A. Монголчуудыг Хятадад уусахаас сэргийлсэн.
 B. Монголыг хоцрогдсон бөглүү нутаг болгож гадаад ертөнцөөс тусгаарласан.
 C. Монголыг хөгжүүлэхэд их гүрний тусламж авах боломж олдсон.
 D. Монголчуудын гадаад харилцаа өргөжиж, олон улс орнуудтай харилцаатай болсон.
 E. Монголчуудын аж амьдрал дээшлэхэд нөлөөлсөн.

33. 1900 онд Манжийг эсэргүүцсэн 2000 монгол цэргийн бослого хаана гарсан бэ? /1 оноо/
 А. Улиастай В. Ховд С. Их Хүрээ D. Хиагт E. Сан бэйсийн хүрээ
34. 1640 онд Тарвагатайн Улаан бураад чуулсан ноёдын чуулганаар “Монгол Ойрадын Их цааз”-ыг батлан гаргасан билээ. Энэ чуулганд хаанахын Монголчуудыг төлөөлсөн ноёд оролцсон бэ? /1 оноо/
 А. Халх В. Ойрад С. Хөх нуурын
 D. Ижил мөрний E. Бүгд оролцсон.
35. Манжийн төрийн шинэ засгийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээнүүдэд хамаарахгүй зүйлийг ялган нэрлэнэ үү? /2 оноо/.
 1. Манжийн төр хятадын худалдаа мөнгө хүүлэгч пүүсүүдийг дэмжих
 2. “Монгол үгийн бодрол” сонинг Хятад Монголоор хэвлэн тараав.
 3. ГМТЗЯЯ-ны бүтцэд “Байцаах товчоо” “Найруулах товчоо”-г шинээр байгуулав.
 4. Ар монголд тусгаар улс байх эрх олгосон
 5. 1905 онд Их Хүрээнд Цагдан цээрлүүлэх яамыг байгуулсан.
 6. Улсын хөрөнгийг захирах газрыг байгуулав.
 7. Манж-Хятад хэлний сургуулиуд байгуулав.
 8. Монголын цэрэг, харуулын байршил, тоог тодорхойлон гаргасан.
 9. Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичгийг мөрдөх болсон.
 А. 1, 3, 5 В. 2, 7, 9 С. 4, 6, 9 D. 1, 4, 6 E. 3, 4, 5
36. Дор дурьдсан шинжүүдийн аль нь ноёд язгууртангууд гэсэн Манжийн үеийн нийгмийн давхрааг тодорхойлж байна вэ? /2 оноо/
 А. Манжийн захиргааны хэрэгт хүчин зүтгэдэг монголын нийгмийн давхрааны дээд хэсэг
 В. Манжийн төрийн олон зүйлийн хүнд хүчир албанд зүтгэдэг цэрэг эр
 С. Аймаг, хошууныхаа ноёд язгууртнуудын мэдэлд захирагддаг харьяат албат
 D. Хутагт хувилгаад, сүм хийдийн мэдэлд захирагдагсад
 E. Манжийн харуулын алба хаадаг хүмүүс
37. Дор дурьдсан түүхэн үйл явдлуудаас Монгол улс/1911-1919/-ын үед болсныг нэрлэнэ үү? /2 оноо/
 1. Улсын дээд, доод хурал байгуулагдав.
 2. Монгол, ЗОУ-ын хооронд найрамдлын гэрээ байгуулжээ.
 3. “Феодал” агчдын хөрөнгийг хураав.
 4. “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” хууль гарчээ.
 5. Хувийн худалдааг хориглохоо больж, худалдаачдад тусламж дэмжлэг үзүүлэв.
 6. Олноор байгуулсан хамтрал, коммуныг татан буулгав.
 А. 1,4 В. 2,4 С. 3,6 D. 5,6 E. 4,6
38. Сурагч Батын аав Дорж одоогийн Архангай аймгийн нутагт төржээ. Энэ нь уламжлалт засаг захиргааны хуваариар аль аймаг вэ? /1 оноо/
 А. Засагт хан аймаг В.Түшээт хан аймаг С. Сайн ноён аймаг
 D.Сэцэн хан аймаг E.Дөрвөд Далай ханы аймаг
39. 1914 онд байгуулагдсан Улсын дээд хуралд хамаарах зүйлийг өгүүлэхдээ илүүц зүйл дурьдсан байна уу? /2 оноо/
 А. Улс төрийн чухал хэрэгт баримтлах бодлого боловсруулан хаанд айлтгах
 В. Яамдын тэргүүн, дэд сайд, ван, бээл, бэйс, гүн, Их шавь, Хөлөнбуйр, Дарьганга, Цахарын зэрэг газрын бүгдийн дарга нар хуралдана.
 С. Хурлыг Ерөнхий сайд удирдана.
 D. Эцсийн шийдвэр гаргах буюу таслах эрхтэй
 E. Энд тийм зүйл дурьдаагүй байна.
40. Доорх газрын зурагт Түшээт хан аймгийн нутгийг хэдийн тоогоор дугаарласан байна вэ? /1 оноо/



- A. 1
 B. 2
 C. 3
 D. 4
 E. 5

41. 1921 оны хувьсгалын удирдагчдын нэг Д.Бодоогийн үйл ажиллагаа, түүхэнд гүйцэтгэсэн үүргийн талаар илүүц зүйл өгүүлсэн байна уу? /2 оноо/
 А. Шинэ толь “Нийслэл хүрээний сонин бичиг” зэрэг сонин сэтгүүлийн ажилд идэвхитэй оролцсон.
 В. 1920 онд ЗОУ-аас тусламж гуйх төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оролцсон.
 С. Хүрээний нууц бүлгэмийг үндэслэгчдийн нэг, МАН-ын анхны дарга.
 D. 1921 оноос АЗГ-ын ерөнхий сайд, Гадаад яамны сайдаар ажилллаж байсан .
 E. Энд ийм зүйл өгүүлээгүй байна.
42. Дор өгүүлсэн зүйлээс аль нь Элбэгдорж Ринчиногийн үзэл бодол вэ? /2 оноо/
 А. “Хэмжээт эрхт хаант засаг бол хуучнаас шинэ байгуулалд шилжих зайлшгүй байх ёстой засаглалын хэлбэр тул тухайн цаг үед нэг хэсэгтээ тохиромжтой.”
 В. “... Бурхны шашнаа хүндэтгэж ард түмнийг амгалан туйл дор хүргүүлэн тэгш, журамт, баян хүчирхэг улс болохыг гол болгосон хэрэг болой.”
 С. “Юун хэмээвээс ертөнцийн хүн төрөлхтөн бүгдээр найрамдах буюу зөвлөлдөх мэтсийн олон зэрэг дэс байр байх бөгөөд үлгэрлэвээс авирах гишгүүрт нэгээс үүсгэн дэвших ба усанд гүехнээс гүнд орохоор утга адил буй”
 D. “МАН-ын эцсийн зорилт нь эв хамтын ёс мөн бөгөөд нам капитал хөрөнгөтний хөгжлийн шатыг алсгах зорилгод хүрэхээр урагшаа давшин явж байна.”
 E. Аль нь ч биш.
43. МАН-ын 1921 оны 3 сарын 1-3-нд болсон зөвлөгөөнөөс гаргасан баримт бичигт “Засгийн эрхийг ард түмэнд шилжүүлэн авч, ардын хуралт сонгуулийг эрхэлсэн гүрэн байгуулбаас зохимой” хэмээн заажээ. Энэ баримтанд ямар гаргалгаа хийж болох вэ? /2 оноо/
 А. Хаант засгийг халах
 В. Парламент бүхий засаглалын хэлбэрийг тогтоох
 С. Бүгд найрамдах засаглалын хэлбэрийг тогтоох
 D. Дээрх бүгд хамаарна.
 E. Зөвхөн А хамаарна.
44. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу. /1 оноо/
 1921.VII.10-нд Ардын засгийн газрын Шүүх яамны тэргүүн сайдаар-ыг томилжээ.
 А. Да лам Пунцагдорж В. Д.Сүхбаатар С. Д.Бодоо D. С.Данзан E. Н.Магсаржав
45. 1921-1924 онуудад соёлын салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг нэрлэнэ үү. /2 оноо/
 1. 1921 оны 11 дүгээр сард Судар бичгийн хүрээлэнг байгуулав.
 2. Анхдугаар үндсэн хуулийг баталлаа.
 3. 1921 оны 7 дугаар сард гадаадын пүүсүүдэд төлөх улсын ба иргэдийн өрийг хүчингүй болгов.
 4. 1921 оны 11 дүгээр сард бага сургууль байгуулагдав.
 5. Байнгын засгийн газар байгуулагдав.
 6. “Уриа”, “Ардын эрх”, “Ардын цэрэг”, “Ургинская газета”, “Манай үнэн” зэрэг сонин хэвлэгдэн гарав.
 7. Ховд, Зүүн Хараад төрийн өмчийн тариалангийн газар-сангийн аж ахуй байгуулав.
 8. Улс орноо цагаантны цэргээс чөлөөлөв.
 9. Хувийн өмчинд байсан жижиг үйлдвэрүүдийг улсын болгов.
 А. 3, 5, 7 В. 1, 2, 3 С. 1, 4, 6 D. 3, 7, 9 E. 7, 8, 9
46. “Феодал” агчдын хөрөнгийг хураах явцад “хувь” гэдэг нэгжийг хэрэглэсэн байдаг. Энэ үед 1 хонь дунджаар 7 төгрөгийн үнэтэй гэвэл 100 “хувь”-ийн хөрөнгөд хичнээн хонь авч үлдэж болох вэ? /2 оноо/
 А. 200 орчим хонь В. 250 орчим хонь С. 300 орчим хонь
 D. 400 орчим хонь E. 430 орчим хонь
47. Зөвлөлт эх орны дайнд БНМАУ ямар байр суурь баримталж байсан бэ? /1 оноо/
 А. Монголын ард түмэн ЗХУ-ын талд байж, дэмжин тусалсан.
 В. Германы талд байж тусласан. С. Энэ дайнд төвийг сахисан.
 D. А ба В хариулт хамаарна. E. В ба С хариулт хамаарна.
48. Доорх төрийн сүлд аль үед хүчин төгөлдөр байсан бэ? /1 оноо/



- А. 1911-1919 оны үед В. 1919-1940 оны үед
 С. 1940-1960 оны үед D. 1960-1992 оны үед
 E. 1992 оноос

49. Дараах үйл явдлуудыг болсон цаг хугацаатай нь харгалзуулна уу? /2 оноо/
- A. БНМАУ НҮБ-ийн бүрэн эрхт гишүүн болов. 1. 1945 он
 B. Улсын тусгаар тогтнолын асуудлаар бүх нийтийн санал асуулга явагдав. 2. 1959 он
 C. Атрын анхдугаар аян эхлэв. 3. 1954 он
 D. “БНМАУ-ын түүх” нэгэн боть бүтээл хэвлэгдэн гарав. 4. 1961 он
- A. A2, b4, c3, d1 B. a4, b1, c3, d2 C. a1, b3, c2, d4
 D. a4, b1, c2, d3 E. a3, b2, c4, d1
50. 1968 оны Мехикогийн олимпоос мөнгөн медаль хүртсэн тамирчин хэн бэ? /1 оноо/
- A. Ч.Дамдиншарав B. Ж.Мөнхбат C. Х.Баянмөнх D. Д.Сэрээтэр E. Т.Артаг .
51. XX зууны монголын урлаг, шинжлэх ухааны зүтгэлтнүүдийн нэрсийг бичсэн нэгдүгээр мөрийг ямар шалгуурыг баримтлан үүсгэсэн байна вэ? /1 оноо/
1. Д.Пүрэвдорж, Р.Чойном, С.Удвал, Б.Явуухулан
 2. Ц.Дамдинсүрэн, Б.Ринчин, Ш.Нацагдорж, Б.Ширэндэв
 3. Б.Дамдинсүрэн, Р.Мөрдорж, Д.Лувсаншарав, Г.Бирваа
 4. О.Цэвэгжав, Г.Одон, Н.Цүлтэм, Л.Гаваа
 5. Ж.Жигжид, Б.Сумхүү, Ж.Бунтар, Г.Жигжидсүрэн
- A. Кино урлагийн салбарын төлөөлөл B. Монголын уран зургийн салбарын төлөөлөгчид
 C. Монголын зохиолчдын төлөөлөл D. Монголын хөгжмийн зохиолчдын төлөөлөл
 E. Монголын шинжлэх ухааны эрдэмтдийн төлөөлөл
52. Социализмын нийтлэг шинжүүдэд үл хамаарах зүйл дурьдсан байна уу? /2 оноо/
- A. Нам төвтэй улс төрийн тогтолцоог хуульчлан баталсан.
 B. Марксизм-Ленинизм цорын ганц зөв онол хэмээн сурталчилна.
 C. Хүмүүсийн бүтээлч сэтгэлгээ, олон ургальч үзлийг бүхий л талаар дэмжиж байв.
 D. Дан ганц улс нийгмийн өмч ноёрхоно. E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.
53. 2002 онд газар өмчлүүлэх тухай хууль гарч гэр бүлийн хэрэгцээнд өмчлүүлэх газрыг засаг захиргааны нэгжээр ялгавартай тогтоожээ. Үүнийг зөвөөр оноож тохируулна уу? /1 оноо/
1. Нийслэлд A. 0.5 га хүртэл
 2. Аймгийн төвд B. 0.07 га хүртэл
 3. Сумын төв, тосгонд C. 0.35 га хүртэл
- A. 1B, 2C, 3A B. 1B, 2A, 3C C. 1C, 2A, 3B D. 1C, 2B, 3A E. 1A, 2C, 3B
54. Монгол улсын малын тоо /мянган толгойгоор/ /2 оноо/
- | Он | Бүгд | Үүнээс | | | | |
|------|---------|--------|--------|--------|---------|---------|
| | | Тэмээ | адуу | үхэр | хонь | ямаа |
| 2000 | 30227.5 | 322.9 | 2660.7 | 3097.6 | 13876.4 | 10269.8 |
| 2010 | 42195.8 | 261.8 | 2122.4 | 2448.3 | 17898.0 | 19465.4 |
- Дээрх баримтаас 2010 оны мал тооллогын дүнг 2000 оныхтой харьцуулж гаргасан гаргалгаанд дор дурьдсан зүйлийн аль нь хамааралгүй вэ?
- A. Мал сүргийн тоо 12 саяар өсчээ. B. Бод мал өссөн байна.
 C. Бог малын тоо өсчээ. D. Хамгийн өндөр өсөлттэй нь ямаа байна.
 E. Дээрх бүгд хамаарна.
55. Өнөөгийн Монгол улсын гадаад бодлогын нэг дэх чиглэл юу вэ? /2 оноо/
- A. АНУ, Япон, ХБНГУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудтай найрсаг харилцаа тогтоох
 B. Хуучин социалист гэгдэж байсан дорнод Европын орнуудтай харилцаагаа сэргээх
 C. Уламжлалт харилцаатай хоёр их хөрш ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх
 D. Азийн бүс нутгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох
 E. НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудтай хамтран ажиллах

56. Өөрчлөлт шинэчлэлийн жилүүдэд соёлын салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг нэрлэнэ үү?
/2 оноо/

1. 2008 оноос иргэнд газар өмчлүүлэх шийдвэр гарч хэрэгжиж байна.
2. Улс төрийн намуудын тухай хууль батлагдан, олон намын систем тогтов.
3. “Монголын нууц товчоо, төрийн хан хуур, морин хуур, төрийн дуулал, төрийн сүлдээ албан байгууллага, айл өрхүүдэд хүндэтгэлтэйгээр залах шийдвэр гарч хэрэгжиж байна.
4. 2009 онд Монгол улсын төрийн тэргүүнээр Ц.Элбэгдорж сонгогдов
5. 2010 оны байдлаар манай орон дэлхийн 114 оронтой худалдаа хийж байв.
6. Монгол бичгээ сэргээх, хос бичигтэн болох ажил өрнөж байна.

A.1, 2, 3 B.3, 4 C.5, 6 D. 3, 6 E. 4, 5


ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ, ДАРААЛАЛ СЭРГЭЭХ ДААЛГАВАР

Санамж:

1. Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү.
2. Зөв хариулт бүр 1 оноотой

2.1 Монгол угсаатны өнөөгийн нутагшлыг газрын зурагт тэмдэглэсэн дугаартай нь тохируулан тэмдэглэнэ үү?
/5 оноо/

- A. Өвөр /Өмнөд/ Монгол
- B. Дээд Монгол
- C. Монгол улс /Ар Монгол/
- D. Ойрад /Өрнөд/ Монгол
- E. Буриад /Умард/ Монгол



2.2 Дараах үйл явдлыг болсон цаг хугацаатай нь оноон тохируулна уу?
/5 оноо/

- | | |
|-------------------------------------------------------------------|------------|
| A. Их Монгол улс байгуулагдсан | 1. 1577 он |
| B. Ил хант улс байгуулагдсан. | 2. 1939 он |
| C. Түмэдийн Алтан хан Төвөдийн Содножамцад “Далай лам” цол олгов. | 3. 1206 он |
| D. Халх голын дайн эхлэв. | 4. 1992 он |
| E. Монгол улсын шинэ Үндсэн хууль /дөрөв дэх/ батлагдав. | 5. 1256 он |

2.3 Монголын эрх зүйн түүхэнд гарсан дараах хууль цаазуудыг батлан гаргасан он цагийн дарааллаар /эхэлж гарснаас нь эхлэн 1-5 гэж дугаарлана/ нь эрэмбэлнэ үү?
/5 оноо/

- A. Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг
- B. Юань төрийн хууль цаазын бичиг
- C. Халх-Ойрадын Их цааз
- D. Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг
- E. Халх журам

2.4 Цэгийн оронд тохирох утгыг нөхөж бичнэ үү?
1990 онд А. 750, 2002 онд В.840, 2006 онд С. 800 жилийн түүхт ойг тэмдэглэв.

D..... ЕБС-ын 11 жилийн сургалттай болгож, Е.хос бичигтэн болох ажил өрнөв.

1. 2005-2005 оны хичээлийн жилээс
2. Чингис хааны мэндэлсний
3. “Монголын нууц товчоо” зохиогдсоны
4. 1991 оноос
5. Их Монгол улс байгуулагдсаны